

XX зууны эхэн үеийн монголын түүх бичлэгийн тойм, онцлог /1911-1920 /

Б.Пунсалдулам

Шинжлэх Ухаан Академийн Түүхийн хүрээлэн

Өгүүллийн товч утга: 1911 оноос 1920-аад он хүртэлхи үеийн түүхийн бүтээлүүд нь бичлэг хэлбэрийн хувьд уламжлалт чиглэлийг түлхүү баримталсан нөгөө талаар түүхийг шинжлэх ухааны үүднээс ойлгож, уламжлалт түүх бичлэгийн хэлбэрээ хянан үзэж шинээр эргэцүүлэн бодох санаачлага идэвхжсэн үе байв.

Түлхүүр үг: Түүх бичлэг, тойм, онцлог, уламжлал

XX зууны Монголын түүхийн шинжлэх ухаан нь хөгжлийн хэд хэдэн шатыг дамжин XXI зуунтай золгожээ. Өнгөрөгч зууны эхэн буюу үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд тогтсон Олноо Өргөгдсөн Монгол улсын үеэс өрнийн шинжлэх ухаан, соёлын нөлөө нэвтрэх таатай нөхцөл бүрдсэн билээ. Энэ үеийн монголын түүх бичлэгт орж ирсэн нэг шинэ зүйл бол түүхийг Монголын төр улсын түүх, тус орны тусгаар тогтнолын ашиг сонирхолтой холбож үзэх явдал, ялангуяа XX зууны эхээр Монголд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн их өрнөлттэй болж ирэх үесээр тун хүчтэй болжээ.¹ Хуучны уламжлалт түүх бичлэгийн зэрэгцээ орчин цагийн түүхийн ухааны мэдлэг, төрийн албан түүх бичлэгийн хүрээний гадна үүсэн дэлгэрч эхэлсэн нь энэ үеийн гол ололт байв. Гэхдээ монголын уламжлалт түүх бичлэгийн хэлбэр давамгайлсаар байв.

1911-1920 оны хооронд монголын түүхийн асуудлаар гарсан ном, зохиол, өгүүлэл, нийтлэл цөөнгүй. Эдгээрийг дотор нь бичлэгийн хэлбэр, агуулгаар нь тогтмол хэвлэл, улсын албан түүх², төр, шашны түүх³, орон нутгийн буюу намтар судлалын⁴ хэмээн ангилан үзэж болохоор байна.

¹ Ш.Бира БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд. УБ., 1977, т-69

² Монгол улсын шастир. II дэвтэр. Хэвлэлд бэлтгэсэн А.Очир нар. УБ., 1997, Н.Магсаржав. Монголын шашин төрийг хослон баригч Богд хааны түүх. УБ., 1924 (гар бичмэл. Түүхийн хүрээлэнгийн номын санд бий), Н.Магсаржав. Монгол ард улсын засаг төрийн байдал хэрхэн уламжилсан явдлыг тайлбарласан бичиг. УБ., 1926, Н.Магсаржав. Монгол улсын шинэ түүх. УБ., 1927

³ Ш.Дамдин. Алтан дэвтэр. УБ., 1931. Ч.Дандаа. Бурхны номын журам бадруулсан эрдэнэт толь хэмээх шашдир. 1913. УННС-д бий. Ч.Дандаа. Шинэ засгийн зүйл. 1915. УННС-д бий. Ч.Дандаа. Шинэ засгийн гол ёс. 1922. УННС-д бий.

⁴ Монгол улсын автономи гэдэг өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухал учрыг тэмдэглэсэн товч өгүүлэл гэдэг түүх бичиг. Хэвлэлд бэлтгэсэн О.Батсайхан. УБ., 1992. Агваанпринлэйжамц. Монгол улсын Олноо Өргөгдсөн Богд хааны түүх. УБ., 2001. Бадамцэрэн. Богд

Монголын үндэсний дэвшилт ардчилсан тогтмол хэвлэл /1913- 1920/- үүд нь Олноо Өргөгдсөн Монгол улсын үеийн түүх бичлэгт зохих байр суурийг эзэлнэ. Монголын ууган тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” (1913 оны зургадугаар сарын 6 - 1914 оны наймдугаар сарын 21)⁵, “Нийслэл Хүрээний сонин бичиг” (1915 оны есдүгээр сарын нэгэн- 1920 оны нэгдүгээр сарын 23)⁶ нь үндэсний дэвшилт ардчилсан үзлийг номлодог соён гэгээрүүлэгч шинжтэй хэвлэлүүд байв. Монголын дэвшилт сэхээтнүүд Оросын хэвлэлийн баазыг ашиглаж тогтмол хэвлэл гаргахыг зорьж байсан бол оросууд уг хэвлэлд өөрийн бодлогыг шургуулах эрмэлзлэлтэй байв. Гэвч уг хэвлэлийг эрхлэн гаргагчид нь Монголын дэвшилт үзэлт сэхээтнүүд /Ж.Цэвээн, Бадрахбаатар, Д.Дорж, Д.Бодоо, Жанцансамбуу / байсан учир анхны дугаараас эхлэн үнэн хэрэг дээрээ хэнээс ч үл хамаарах бие даасан бодлоготой тогтмол хэвлэл байжээ.

Дээрх сонинг эрхлэн гаргагчид нь Монгол үндэстний тусгаар тогтнол, улсын эрх чөлөөт байдлыг хамгаалж, тогтоохыг гол болгон бичихийн хамт тухайн үеийн нийгмийн байгуулал, засаг-захиргаа, шүүх дэглэмийг шүүмжилсэн өгүүлэл олноор нийтлэн гаргаж байв. Улс орныг шинэчлэн өөрчилж, аж ахуйн дэвшилт шинэ хэлбэрийг буй болгон хөгжүүлэх, улмаар шашны ноёрхлын эсрэг гэгээрэл шинжлэх ухааны асуудлыг дэвшүүлсэн өгүүллүүдээрээ соёл боловсролыг эрчимтэй хөгжүүлэхийн чухлыг сурталчилж байв. Хэвлэлийн хуудсаар шинэ ёсны түүхийн мэдлэг ухаан дамжин дэлгэрч байв. Тухайлбал “Шинэ толь”-д Францын Гранстромын “Хөх Монголын хөх туг” түүхэн роман, Финляндын монголч эрдэмтэн Рамстедийн бичсэн “Уйгар улсын хураангуй түүх” зэрэг монголын түүхэнд холбогдох зохиолууд нийтлэгджээ. Ийнхүү Монголын дэвшилт ардчилсан сонингууд нь тухайн үеийн үйл явдлыг тусгаж харуулахын зэрэгцээ монголын ард түмний дэвшилт ардчилсан үзэл,

Жибузундамба хаан ширээнд заларсны нууц түүх- Ялгуулсан хөвгүүний баясгалангийн хуримын далай хэмээгдэх оршвой. УННС-гийн монгол гарбичмэлийн хөмрөгт

⁵ “Шинэ тольхэмээх бичиг” анхны дугаар нь 1913 оны 6-р сарын 6 нд гасан. Тус сонины эхний дөрвөн дугаар нь 23х15 см-ийн хэмжээтэй 50-60 хуудастай сэтгүүлийн маягаар, дараах 16 дугаар нь 34х26 см-ийн хэмжээтэй 6-10 нүүр бүхий сонины хэлбэрээр 20 дугаар гарчээ. Нэг дугаар нь 500 хувиар гарч Гадаад Монголын төрийн байгууллагуудад үнэгүй тараагдаж, уншигчдад сонин худалдаалах цэгээр дамжин тардаг байв. Эдүгээ Монголын Үндэсний төв архивт “Шинэ толь хэмээх бичиг” сонины №7-14, 19, 20 гэсэн нийт 10 дугаар хадгалагдаж байна.

⁶ “Нийслэл Хүрээний сонин бичиг” долоо хоног тутамын хэвлэл. Эхний 1-19 ба 39-103 дугаар нь 35х26 см-ийн хэмжээнд, 20-38 дугаар нь 45х36 см-ийн хэмжээнд тус бүр зургаан нүүрээр хэвлэгдэн гарсан байна. Монголын Үндэсний Түүхийн төв архивт тус сонины № 4, 7,8,9,13, 39-51, 61-63, 65- 73, 75-77, 79-88, 101, 103 гэсэн нийт 45 дугаар хадгалагдаж байна.

үндэсний ухамсар, түүхийн мэдлэг ухаан, түүх бичлэгийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн нь эргэлзээгүй юм.

Монгол улсын засгийн газраас эх орондоо орчин цагийн шинжлэх ухаан, соёл боловсролыг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байв. “Монгол орныг шинжин үзэж, тухайн хэрэг шийтгэх хороо” гэдэг нэртэй эрдэм шинжилгээний байгууллагыг Оросын эрдэмтдийн шууд оролцоотойгоор байгуулан ажиллаж байсан нь монголчууд эх орондоо шинжлэх ухаан, соёл боловсрол, эх түүхээ үүсгэн хөгжүүлэх гэсний нотолгоо юм. Олноо Өргөгдсөний 4 дүгээр оны 12 дугаар сарын 27-нд дээрх хорооны дарга, Монголын засгийн хэрэгт зөвлөх түшмэл С.А.Козин, Шүүх таслах яамны дэд сайд, дайчин жонон ван Цогбадрах, Сангийн яамны туслан шийтгэлцэх дэд сайд гүн Цэнд, Бүгд ерөнхийлэн захирах яамны дэс түшмэл, итгэмжт түшээ гүн Цогт-Очир, Гадаад яамны дэс түшмэл Бавуудорж нарын зэрэг хүмүүс цугларан хуралдаж тус хорооны дүрмийг батлан гаргажээ. Уул дүрэмд Монгол орныг шинжин үзэх хорооны дотоод зохион байгуулалт, эрх үүргийн тухай тодорхой бичжээ. Энэхүү хороо нь эрдэм шинжилгээний хэргийг эрхэлсэн манай улсын анхны байгууллага байв.

Мөн Монгол улсын Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд түүх шашдир хариуцсан тусгай түшмэлийн орон тоо байжээ. Энэ тухай “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-т: Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам нь түшмэл, ёслол, төв гурван хэлтэс буй. Төв хэлтэст эх бичиг зохиогч түшмэл хоёр хүн, жинхэнэ бичээч 5 хүн улсын шастир, хууль зүйл, гэрээ бичиг, өрх амны данс, газар орны зургийг хадгалж зах хязгаар нутаг үндсэнд холбогдох хэрэг, өртөөний засгийг эрхэлнэ.¹ хэмээн тодорхой заасан байна. Эдгээр нь Монголын үндэсний соёл, шинжлэх ухааны түүхэнд гарсан томоохон ололт мөн бөгөөд энэ нь шинэ түүх бичлэг тэрлэн хөгжих таатай нөхцлийг бүрэлдүүлжээ.

Үүний тод жишээ бол Монгол Улсын Засгийн Газраас /Дотоод явдлын яамнаас эрхлэн/ 1913-1918 онд “Зарлигаар тогтоосон Монгол улсын шашдир” хэмээх улсын албан түүхийг зохиолгосон явдал юм. Уг зохиол нь Олноо Өргөгдсөн Монгол улсын үеийн түүхийн бүтээлүүдийн оргил бөгөөд энэ үеийн түүх бичлэгт гарсан нэг шинэ үзэгдэл байв. Энэ нь **нэгдүгээрт**: Зарлигаар тогтоосон Монгол улсын шашдир” нь хамтын бүтээл. Шашдирыг зохиох ажлыг Нийслэл Хүрээний урьд тушаалын дээд сайд, да лам Цэрэндэндэв, Их Хүрээний да лам, хурц билэгт Гомбоцэрэн, сэцэн хан

¹ Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ., 1995, т.13

аймгийн хурц гүн Галсан доной нар тэргүүлж, гавж (Заваа) Дамдин, гүүш Сумъяа, гүн Дашням мөн Намсрайжав, Тогтох нар туслан оролцжээ. **Хоёрдугаарт:** Шашдирыг зохиохын тулд тэр үеийн Халхын дөрвөн аймаг, Дөрвөдийн хоёр аймаг, Их шавийн зэрэг газруудын ноёд, тайж нар хутагт хувилгаадын уг эх, гэрийн үеийн бичмэлүүдийг зарлан авчруулж ашигласны зэрэгцээ Манж чин улсын үед зохиогдсон “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, хотон аймгуудын ван гүнгүүдийн илтгэл шашдир” болон бусад хуучин судар бичгүүдийг хэрэглэжээ. Энэ нь төв орон нутгийн аймаг хошуудын албан бичиг, данс хараа зэргийг түүх бичлэгт анх удаа зохих хэмжээгээр ашигласнаас биш, хуучин түүхийн хэвшмэл арга-элдэв домог сэлтийг огт хэрэглээгүй онцлогтой. **Гуравдугаарт:** Шинэ тусгаар тогтносон Олноо Өргөгдсөн Монгол улсын анхны албан түүх бөгөөд эх түүхээ зохиох, бичих ажлыг засгийн газрын зүгээс зориуд хөхүүлэн дэмжиж байв.

“Монгол улсын шашдир” нь бүхэлдээ XVII-XX зууны эхэн үеийн Ар Монголын нөлөө бүхий ноёд, тайж, хутагт хувилгаадын намтарыг он цагийн дараалалд нь цэгцтэй товч тодорхойлон гаргаж чадсан үнэ цэнтэй чухал сурвалж юм. Уг бүтээлээс тухайн үеийн Монголын засаг захиргаа, хошуу, сум, хийдийн зохион байгуулалт, тоо зэргийг мэдэж болно. Зарлигаар тогтоосон Монгол улсын ерөнхийлэн үйлдсэн шастир арван нэгдүгээр дэвтэрт Боржигэд овог, Хиад яс, таван өнгө, дөрвөн харь зэрэг үгүүдийг тайлбарлан бичээд, Монгол хаадын хаан суусан хугацаа, Чингис хааны есөн өрлөг, Чингисийн дөрвөн хатан тэднээс гарсан хан хөвгүүд, тэдний үе удам, Хубилай сэцэн хаан Хятад улсыг авсан, Нийслэлийг шилжүүлсэн, Пагва лам монголын дөрвөлжин үсэг зохиосон зэргийг товчхон гаргасан байна. Мөн манай улс ерөөсөө эртний тусгаар улс байсан бөгөөд харин Манж улсад нэг хэсэгтээ дагаар орж явсан боловч тусгаар улсыг байгуулан Монголын тулгар төрийг дахин нээж Манжаас тусгаарласан болохыг онцлон тэмдэглэхийн хамт 1911 оны үндэсний хувьсгал гарах шууд нөхцөл нь Манжийн төрөөс монголд явуулсан бодлого байсныг “Бас байн байсаар Манж хааны эрх баригчид шашин төрийн ёс журам, цааз хуулийг хүндэд дагаж явахыг зэргээр огоорч хэрэг тутам хөдлөх бүр эд юм хахуулилан авах, ашгийг хичээснээс зөв хэргийг бурууд, буруу хэргийг зөвд үзэж, үнэхээр цааз сахилгыг нэгмөсөн алдагдахуйд хүрч, тэр энэ хэмээн ялгах явдалгүй, цөм бие хөрөнгө тэсвэрлэн чадахгүй болсонд арга буюу манай Халхын монголчуудын шашин төрийн эрх баригчид санаа цутгаад зөвлөлдөж, бүх олны явдал итгэл болсон Очирдара багш

Жавзандамба лам юугаа Монгол улсын шашин төрийг хослон баригч Богд эзэн хаан болгон эрдэний сууринд сайн өдрийг сонгон залж тахиглан суулгаж..." хэмээн тодорхой гаргажээ¹.

"Монгол улсын шастир" доторхи "Ерөнхийлэн үйлдсэн шастир" болон өдгөө олдоод буй шастируудын дэс дугаар зэргээс үзвэл, "Монгол улсын шастир"-ыг 11 дэвтрээр зохиосон буюу зохихоор төлөвлөн гүйцэтгэж байсан бололтой. Энэ тухайд зарлигаар тогтоосон Монгол улсын ерөнхийлэн үйлдсэн шастир арван нэгдүгээр дэвтэрт "Шастирт хэрэглэгдвээс зохих ном судар, хуучин шастир эл бичгүүдийг хянан үзэж, бүгдээр боловсрон зөвлөлдөж, анги хуваан орчуулж бичүүлэн харъяат бүх улсын Их шавь Халхын дөрвөн аймаг, Дөрвөд хоёр гарын зэрэг олон газруудын шастирыг нийгэмчлэн зохиоход эн тэргүүнээ эрхэлбээс зохих Очирдара багш Богд эзний шастирыг гүнээ хичээнгүйлэн номын ёсоор зохиож таван дэвтэр болгон өөр өргөх ба бусад Их шавийн хамба, шанзудба, да лам нар, ван гүнгүүд, урьд шавга татуулсан ба үгүй, тамга бүхий, үгүй, хутагт хувилгаан нарын шастирыг чухам дээд, дэд дээд хоёр дэвтэр болгон (Мөн шавийн шашны хурлын сүм хийдийг жагсаан бичсэн товъёгийг чухам доод дэвтэр болгон) Халхын дөрвөн аймаг, Дөрвөд хоёр гарын зэрэг газрын засаг ба засаг бус олон ван гүнгүүдийн шастирыг таван дэвтэр болгон басхүү олон аймгийн тамга бүхий, үгүй хутаг хувилгаан лам нар ба бас бус ерөнхийлэн үйлдсэн шастирыг чухам доорд, дэд доорд хоёр дэвтэр болгон бүрнийг дэвтэр тутам товхиж үүнээс дээш бүгд есөн (арван нэгэн) дэвтэрийг нийтээр товхихын урьд хэвд даруулж анги ангиар хавтас дугтуй үйлдэж сайтар гүйцээгээд, өөр өөрийн зохих газруудад нэгэн адил тархаан хүргүүлж өчүүхэн шиг цалгардан хайш хэрэгт хүргүүлэхгүй болгон нарийн чандад хадгалуулж хойч үед хоцроож, төрөл овог, гавъяа эндэгдлийг хялбараар мэдэхийн тулд цагийг дагаж хуучныг журамлан шастир шинэчлэн зохиов" хэмээн дурджээ².

Монгол улсын шашдирыг эрдэмтэн Х.Пэрлээ³, Ш.Бира⁴ нар түүх бичлэгийн талаас нь судлаж зарим үнэлэлт дүгнэлт өгч байсан боловч бүхэлд нь нийтлүүлж, эрдэм шинжилгээний эргэлтэд бүрэн оруулаагүй байсан юм. Харин түүхч А.Очир, З.Лонжид, Ц.Төрбат нар анх удаа энэ зохиолыг нийтлүүлж, ингэхдээ Богд

¹ Монгол улсын шашдир. II боть. УБ., 1997, т-84

² Мөн тэнд, т-82

³ Х. Пэрлээ. Хувьсгалын өмнөх Монголын түүх бичлэгийн асуудалд. УБ., 1958, т-31

⁴ Ш.Бира. БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд. УБ., 1977, т-70

Жибзундамбын холбогдолтой хэсгийн дутуу, олдохгүй байгааг харгалзан монгол улсын төв номын сангийн гар бичмэлийн хөмрөгт хадгалагдаж буй Жибзундамба нарын намтарыг кирилл бичигт буулгаж, үзэж судлах хүнд тус болохоор дэд ботийн хавсралт болгон хэвлүүсэн байна¹. Энэ хавсралтанд нийтлүүлж буй намтрыг хэн хэзээ зохиосон нь тодорхойгүй бөгөөд Богд Жибзундамба нарын намтарыг Энэтхэгт тодорсон анхан дүрээс эхлэн 23 дугаар дүр буюу 1870-аад оны эхэн хүртэлх үеийг хураангуйлан өгүүлжээ.

Монгол улсын засгийн газраас улсын түүх шашдрыг зохиоход ихээхэн анхаарч байсны нэг илрэл нь улсын шашдир зохиох болон хууль зохиох газарт хэрэглэгдэх Дайчин улсын Бүгд хууль цаазын бичгээс орчуулах ба шинэ зохиосон хууль зүйлийн эхийг сийрүүлэх, Манж толь бичиг орчуулах зэрэг албыг гүйцэтгэсэн хүмүүсийг хөхүүлэн шагнаж хишиг хүртээж байсан байна. Энэ тухайд Дотоод хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны бичиг: Түшээт, Сэцэн, Сайн ноён хан аймгийн чуулган дарга, Нийслэл Хүрээний Эрдэнэ Шанзудба нар дор тушаан илгээсэн бичигт: Тушаан явуулах учир энэ он 10-р сарын 15 нд манай Дотоод яамнаа айлтгасан нь Шашдир зохиосон ба хууль бичгийг дармал дарах зэрэг албанд зүтгэснийг зохисоор хөхүүлэх явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд бээр толилон заан айлдахыг гуйхын учир... Зарлигийг гуймой хэмээн айлтгасанд мөнхүү сарын 17-ноо хүлээн авсан уг нугалбарт улаан бийрээр цохсон нь: Минжүүрдоржид харавтар улаан өнгийн жолоо, Галсандоржид үе улиран улсад туслагч гүнгийн зэрэг, харавтар улаан өнгийн жолоо, Цэрэндэндэв агсны эхэд мөнгө 300 лан, Намсрайжавт нэг нэмсэн, нэг тэмдэглэсэн зэрэг, Гомбоцэрэнд түшээ гүнгийн зэрэг, Тогтоход хоёр тэмдэглэсэн зэрэг, шашдир бичсэн Гончигдаш нарын таван хүнийг зэрэг дэвшүүлэхийг хэрэгсэх үгүй болгож өөр өөрийн нэгжгээд тэмдэглэсэн зэрэг, Элбэгбатад мөнгө 50 лан тус тус шагнаан бусдыг гуйсан ёсоор болгогтун хэмээснийг хичээнгүйлэн дагаж манай яамнаас дээрийн хишигт мөргөсний тулд эдний нэр, зэргийг өөр өөрийн бичгийн хойно жагсаан бичиж үүнийг Түшээт хан, Сэцэн хан, Сайн ноён хан аймгийн хамаарсан чуулганы Дарга нарт тус бүр тушаан явуулаад уламжлан зохих газруудад тушаан дагаж явуулая. Үүний уг нэр зэргийг хэвээр бичиж Гадаадын зэрэг дөрвөн яамнаа явуулан байцаан үзүүлэхээс гадна Сангийн яамнаас эл хоёр зүйлийн шагналын мөнгийг зохиогчдод тавин олгох ажаамуу. Үүний тул тушаан илгээв. Олноо

¹ Монгол улсын шашдир. II дэвтэр. Хэвлэлд бэлтгэсэн А.Очир нар. УБ., 1997

Өргөгдсөний 9-р он арван сар хэмээн бичээд тусгай хуудас дагуулан бусад шагнагдах хүмүүсийн нэрсийг бичжээ.

Өгүүлэн буй үед түүх судлалын салбарт үндэсний дэвшилт ардчилсан үзэлтэй хуучны түүхчид буюу бичгийн хүмүүс уламжлалт ёсыг баримтлан ард түмнийхээ түүхийг судлан боловсруулах талаар нилээд зүйлийг хийжээ. Тухайлбал гавж /Заваа/ Дамдин, Бадамцэрэн, гүүш Сумъяа, гүн Дашням, Нямжав Л.Дэндэв, Н Магсаржав, Ч. Дандаа зэрэг хүмүүсийг дурдаж болох юм.

Ч. Дэмчигдорж (1963-1932)¹ 1910-1913 онуудад “Эрдэнэт толь хэмээх шашдир” дөрвөн дэвтэр, 1915 онд “Шинэ засгийн зүйл” 1922 онд “Шинэ засгийн гол ёс” хэмээх түүхийн бүтээлүүдээ туурвижээ. “Эрдэнэт толь” нь бүхэлдээ буддын гүн ухаан, сургаал дээр суурилж нүүдэлчдийн ахуй, зан заншил, ёс суртхуун, уламжлалт сэтгэлгээг Күнз, Нагаржунай зэрэг эртний дорно дахины философичдын үзлээр баяжуулан өөрийн гэсэн үзэл бодлоо дэвшүүлэн тавьсан сурах бичгийн шинжтэй бүтээл гэж үзэж болно. Уг бүтээл дөрвөн дэвтэр, 64 бүлэг, нэг, хоёр, гуравдугаар ангийн шүлэгт зарлиг, тогтсон дүрэм хэмжээ 24 зүйл дүрэм гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. “Эрдэнэт толь” хэмээх шастирыг түүхч Д.Дашбадрах анхлан бүрэн эхээр кирилл үсэгт буулган өмнөтгөл хийж хэвлүүлсэн нь талархууштай.

“Шинэ засгийн зүйл” хэмээх бүтээл нь 25 зүйлээс бүрэлдэнэ. Энэхүү бүтээл нь шинэ тутам байгуулагдсан Монголын төрийг хүчирхэг болгох, хуучны үзэл сурталтай хутгалдан мухар сүсэгт баригдсан нийгмийг шинэчлэх, ард олныг боловсруулж соён гэгээрүүлэх үүднээс бичигдсэн шүүмжлэлт сургаалын шинжтэй бүтээл байв.

“Шинэ засгийн гол ёсон” бүтээлээ 1922 онд бичсэн. Уг зохиол бүхэлдээ улс төрийн өнгө аястай, ардын засгийн газрын үйл хэрэг, үзэл бодлыг тууштай дэмжин ард олныг ухуулан сэнхрүүлэх зорилготой бичигдсэн нь ажиглагдана. Уг бүтээлийг ардын засгийн захиалгаар бичсэн ч байж болох талтай юм. Дээрх хоёр бүтээлийг 1991 онд “Бодрол баясалгал” сэтгүүлд цувралаар нийтлэж олон түмний хүртээл болгожээ.

¹ Чимэдийн Дэмчигдорж. Бичгийн өргөмөл нэр нь Дандаа. Дандаа хэмээх нэр нь “ханьсах саран” буюу “тэнцэшгүй, ханьцашгүй өрсөлдөгч, тэмцэлдэгч” гэсэн төвд үг бололтой. Өвөр Монголын Ёстын чуулганд төрж өссөн, хятад, япон, манж, төвд, монгол хэл бичигт нэвтэрхий боловсорсон. 1904-1914 онуудад голдуу сэтгүүлчээр Бээжин зэрэг газруудад ажиллаж байсан. 1914 оноос Ар Халхад шилжин суурьшиж олон шавьтай болж нилээд ном зохиол туурвисан эрдэмтэн хүн юм. Үүний зэрэгцээ тулгар тусгаар тогтносон Монол улсаа хөгжүүлэхэд анхаарал тавьж, улс оронд тустай санал хүсэлтийг Улсын Дээд Хуралд өргөн барьж байсан. Тэр хувьсгалын дараа БНМАУ-ын Судар бичгийн хүрээлэнгийн жинэхэн гишүүнээр сонгогдож байжээ.

Тэрээр түүхийн ном бүтээл хийхийн зэрэгцээ хятад хэлнээс “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл”, “Тан улсын журамт найман эрийн явдал” манж хэлнээс “Мэргүүг жолоодох” гэдэг хоёр дугтуй арван дэвтэр ном, япон хэлнээс “Дайчин улсын үеийн их ази тив”, “Цагаан чөтгөрийг үлдэн хөөсөн нь”, түвд хэлнээс “Хүргэн бэрийн зурхай” зэрэг түүх, уран зохиолын орчуулгыг хийхийн хамт Богд хаант Монгол улсын сургуулиудад үзэх сурах бичгийг зохиожээ.

Түүний орчуулга дотроос хамгийн дорвитой нь 1917-1922 онд хятад хэлнээс орчуулсан “Юан улсын түүх”¹ хэмээх монголын түүхийн 210 дэвтэр зохиол юм. 1916 онд Монгол Улсын Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамны дэд сайд бөгөөд Сайн ноён хан аймгийн засаг ноён Далай чойнхор ван Цэдэнсоном Улсын Дээд Хуралд “Юан Ши” –г орчуулах саналыг гарган учир шалтгааныг тодорхой тусгажээ.² Улсын хурал энэ саналыг сайшаан тухайн үед Нийслэл Хүрээнд сууж байсан түшмэл Дандааг урьж энэ тухай санал болгоход тэрбээр дуртайяа зөвшөөрч орчуулахаар тохиролцжээ. Мин улсын анхны эзэн хаан Чжу Юан жан (1368-1398)-гийн зарлигаар 1369-1370 онд Сун Лянь, Ван Вей тэргүүтэй хэсэг түүхч эрдэмтний зохиож хэвлүүлсэн 210 боть “Юан ши” буюу “Юан улсын судар”-ыг 1917 оноос эхлэн орчуулсан боловч Монгол оронд улс төрийн хямрал нүүрлэж хэд хэдэн төр солигдсон. Гэвч тэрбээр долоон жилийн турш уг номыг тасралтгүй орчуулсаар 1923 онд дуусгаж, Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн түшмэл бөгөд эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээнд хүлээлгэн өгсөн байна. Эдүгээ Монгол Улсын Номын Сангийн гар бичмэл номын хөмрөгт “Юань улсын судар” –ын хоёр бүрэн эх болон хэд хэдэн дутуу эх хадгалагдаж байна. Сүүлийн үед энэ чухал сурвалж бичгийг хэвлэн нийтлүүлж, олон түмний хүртээл болгох ажилууд хийгдэж байна. Тухайлбал: УННС-д буй “Юан улсын судар”-ын олон бичмэлийг харьцуулан үзэж, хамгийн бүрэн бүтэн, алдаа мадаггүй, Дандаагийн өөрийн гар бичмэл мөн хэмээн үзсэн эхний хураангуй дээд, доод I-XI дэвтрийг Ц.Цэрэндорж хэвлэлд бэлтгэн 2003 онд гаргажээ³. Мөн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан А.Алимаа нар “Юан улсын

¹ “Юан улсын судар” –ын нэг бүрэн эхийн 1-210-р дэвтэр нь 1995/ 96[]-аас 2203/ 96[3591] дугаартай, харин хураангуй дээд, доодыг дэвтрээр товхисон нь 1128/ 96[3382] дугаартай УННС-д хадгалагдаж байна.

² Улсын Дээд, Доод Хурал /Баримт бичгийн эмхтгэл/ -I.Эмхтгэсэн .Ж.Гэрэлбадрах нар. УБ.,2003,т-225

³ Ч.Дандаа. Юан улсын судар. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Цэрэндорж. УБ.,2003

судар"-ын эхний гурван дэвтэр, хураангуй дээд, доодыг кирилл үсэгт буулган хэвлүүлжээ¹.

Дандаа бол үнэхээр төрийн мэргэн түшээ, ухаан төгс эрдэмтэн байсан нь түүний бүтээл туурвилуудаар тодорхойлогдохын сацуу тэрбээр монгол улсаа төвшитгөн тохинуулахын тулд санаа тавин хичээн чармайж оюун бодлоо шавхан сэтгэдэг эгэл бус нэгэн байсныг улсын хуралд түүний удаа дараалан өргөсөн санал бодролуудаас нь мэдэх боломжтой.

Дандаагийн бүх бүтээлийн "амин сүнс" бол тэрбээр Монгол улсаа тухайн үед ба ирээдүйд хэрхэн хөгжүүлэхэд зайлшгүй анхаарууштай олон зүйл сэдэв дэвшүүлж, тэдгээрийг бодитой хэрэгжүүлэх арга замыг хэн боловч хялбархан ухаарахуйц хэл найруулгатай бичсэн байдгаараа тухайн үеийнхээ эрдэм номтой түшмэд бичгийн хүмүүсээс онцгой содон юм.²

XX зууны монгол туургатны дотроос тодрон алдаршсан нэрт зүтгэлтэн Ж.Цэвээн (1881-1938)³ Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал ид өрнөн ялах үеэр Монголд цаг мөч алдалгүй яаравчлан ирж 1917 оны эх хүртэл олон талаар идэвхлэн оролцож, Олноо Өргөгдсөн Монгол улсын Гадаад явдлын яамнаа соёл эрхэлсэн түшмэлээр ажиллаж байсан бөгөөд энэ хугацаандаа монголын анхны тогтмол хэвлэлийг эрхлэн гаргаж, 1915 оны удтал үргэлжилсэн гурван улсын Хиагтын хэлэлцээрт эксперт, орчуулагчаар оролцож, түүх, шинжлэх ухааны бүтээл туурвиж, орчуулга хийж бүтээлчээр ажиллаж байжээ. Тэрээр монголд шинжлэх ухааны мэдлэг дэлгэрүүлэхийн тулд найман төрлийн цуврал хэвлэн нийтлэхээр туурвсны нэг нь Монголын түүх буюу европ, дэлхийн түүхийн асуудлыг хөндсөн цуврал байв. Ж.Цэвээн 100 орчим шинжлэх ухааны буюу уран зохиолын ном олж цуглуулан Нийслэл Хүрээнд авчирч түүнээсээ орчуулан хэвлүүлсэн байна. Тэдгээр номын дотор европын нэрт түүхч Г.Эрвегийн зохиосон "Европ, Францын түүх" хэмээх ном байсан бөгөөд түүнд европ, франц улсын түүхийг эрт үеэс эхлэн 1900 оны үе хүртэл улируулан бичсэн дөрвөн дэвтэр ном байв. Мөн Францын Гранстромын "Хөх

¹ Юан улсын судар. Хэвлэлд бэлтгэсэн А.Алимаа нар. УБ.,

² З.Лонжид. Улсын хурал ба эрдэмтэн Дандаа. "Түүх"-II сэтгүүл. №211(20) 2003 он, т-103-104

³ Жамсрангийн Цэвээн 1881 онд Буриадад төрсөн. 1892 оноос Чит, Иркутск, Петербург хотуудад бага, дунд, дээд боловсрол эзэмшсэн. 1903 оноос Буриад, Халх, Өвөрмонголоор явж ардын аман зохиолын материал цуглуулж байсан.

Монголын хөх туг", профессор Хвольсоны " Хүн төрөлхтөнд шинжлэхүй ухааны холбогдол" зэрэг нэрт эрдэмтийн зохиол бүтээлүүд нь өгүүлэн буй Монгол улсын түүх бичлэгийн хөгжилд зохих хэмжээгээр нөлөөлсөн нь дамжиггүй юм.

Монголчууд хуучин цагт түвд хэлээр ном зохиол их бичдэг заншилтай байсан бөгөөд тэдний бичсэн олон арван зохиол бий. Бидний өгүүлэн буй Богд хаант Монгол улсын түүхийн судалгаа, түүх бичлэгт ч түвд хэл дээр бичигдсэн монголын түүхийн зохиолууд зохих байр суурийг эзэлдэг. Гол төлөөлөгч нь Шагдарын Дамдин, Агваанпринлэйжамц нар юм.

Ш.Дамдин (1867-1937) бол Монголын хуучин цагийн түүхчдийн нэг бөгөөд түүний амьдарч, ажиллаж байсан цаг бол Монгол орны түүхэн хөгжлийн асар их өөрчлөлт, хувьсгалын үе байв. Тэрээр бүгд 12 боть ном бичсэнээс нилээд нь түүхийн зохиол байв. Тухайлбал Их Хүрээний Гунгачойлон чойрын түүх, Чойеннодсалин чойрын түүх, Сайн номлолын рашааны дусал гэдэг он дараалалын бичиг, Өлзийт далай инээсний дуун эгшиг (Монголд шашин дэлгэрсэн тухай түүх) зэрэг номуудыг түвд хэл дээр бичихийн хамт бас орчуулгын ажлыг хийсэн байна. V зууны Хятадын алдарт жуулчин Фа-сяний замын тэмдэглэлийн түвд орчуулгыг 1918 онд орчуулсан байна. Түүний түүхийн зохиолууд дотроос хамгийн том хэмжээний бүтээл нь "Алтан дэвтэр" бөгөөд уг номны бүтэн нэр нь "Замбуулингийн хойд зүгийн их Монгол гүрний түүх их шастра, шинжээчинийг гайхуулагч Алтан дэвтэр" (Монгол бар, 301 хуудас) "Алтан дэвтэр" таван бүлэгтэй.

Дамдин зохиолоо хуучин түүх бичлэгийн арга хэлбэрээр бичиж, түүхийг үзэх буддын шашны онолыг баримтласан ч гэсэн уламжлалт түүх бичлэгт байхгүй өөрийн өвөрмөгц шинэлэг талыг шингээж чадсан юм. Тэрээр хуучны түүхчдийн хэвшмэл заншлыг эвдэн монголын түүхийг манай орны нутагт оршиж байсан эртний аймгуудын түүхээс эхлэн бичжээ. Уг бүтээлд Монголын нутагт байсан эртний аймгуудын түүх, Халх дөрвөн аймгийн үүсэл, халхын тайж нарын гарал үүсэл, Ойрдын Гүүш хан, Галдан Бошигт, Амарсанаа, торгуудын Аюуш хааны тухай, дэлхий ертөнцийн байдал, монгол газар орны тухай, монголд шашин дэлгэрэн хөгжсөн, Монгол Түвдийн улс төр, соёл, шашны харилцааны түүхийг тусгасан байна. Академич Ш.Бира "Алтан дэвтэр"-ийг тусгайлан судлаж үнэлэлт дүгнэлтийг өгсөн байна¹.

¹ Ш.Бира. "О Золотой книге" Ш.Дамдина. УБ., 1964

Лашин Агваанпринлэйжамцын "Жибзун дарнатын гэгээний дээд хувилгаан Агваанлуvsанчойжинямданзанваанчигбалсанбогийн дүр хийгээд түүхэнд ялгуулсан бээр бошог үзүүлсэн ба хааны угсааны ёсыг тодруулан үйлдсэн эндүүрэлт үзэгдлийг машид арилгагч, шашин төрийн наран саран хосолсны гэрлийн гэгээ хэмээгдэх оршив" хэмээх¹ зохиолын II-IV хэсэг бүхэлдээ VIII Богд жибзундамбыг ОӨМУ-ын хаанаар өргөмжилсөн лүгээ холбогдуулж, Энэтхэгийн хүрдэн эргүүлэгч хаад, түвдийн номт хаад, монгол хаад, төр ёсны уламжлалыг дараалан өгүүлж, бошог үзүүлсэн үндэслэлийг тодруулан Богдыг хаанд өргөмжилсөн түүхэн нөхцөл шалтгаан, тэр үеийн монголын нийгэм, нийгмийн зарим бүлэг давхраа Богд хааныг хэрхэн үзэж байсан, Богдын намтар, үзэл санааг тэтгэн гаргахад зориулагджээ. Тэрээр зохиолын анхдугаар савжид буюу хуваарьт Өндөр гэгээний өмнөх буюу хойд дүрүүдийг Энэтхэгт 8, Түвдэд 16, Халх Монголд 2, бүгд 26 хутагтыг тодруулсан байна.

Зохиогч тэр үеийн Монгол орны дотоод гадаад ертөнцийн талаар, тухайлбал Манжийн төрөөс явуулсан шинэ засгийн бодлого, Хаант Оросын болон Хятадын мөнгө хүүлэл-худалдаачдын мөлжлөгийг "Хар Хятад хийгээд Орос, Манж тэргүүтэн хэвцгий догшин хилэнцтэн болшгүй ноёд түшмэд шимнус язгууртан башир хуурмаг мэх гурваар хаан гүрний нийтийн амьтан бүгдийн эд таваар эдлэл хогшлыг хүчээр булаах бөгөөд гэм үгүй мэтийг буруу цаазаар цаазлах ба суварга, сүм, шүтээн ба хааны үе угсаа, удам эцэс хязгаарлашгүйгээс нандин шүтээн ялгамжтай бурхан бодитой лугаа адилын Зандан зуугийн гүсэг тэргүүтнийг түлсэн ба зарим нэгийг эвдсэн хийгээд зарим газар хөсөрт хаясан ба ханы ордны ойр хавийн дацан, олны хурал номын журмыг үргэлж сөнөөж, зогсоосон хийгээд тэдгээрийн сүм дуган бүхэнд малын хашаа хийгээд гахайн хашаа болгоод гурван эрдэний хэрэгсэл бүгдийг сүйтгэх ба монголын хувраг гавжийн мяндагтан бүгд хятадын ямханчууд лугаа хамт нэгнээ нөхөрлүүлэхийн үүднээс хар болгохын муу журмыг тогтоохуйд завдсан ба хэрэв түүнд орохгүй хувраг тойныг цаазаар цаазлах хэрэгтэй хэмээсэн..."², хэмээн Монгол оронд Үндэсний хувьсгал гарах нөхцлийг тодорхойлоод, 1911 оны Үндэсний хувьсгалын гол удирдагчдын нэг Богд Жибзундамба хутагтын түүхийг өндөрт өргөж, бусад удирдагчид, зүтгэлтнүүдийн тухай огт дурдаагүй байгаа нь манай хуучин цагийн түүх

¹ Агваанпринлэйжамц. Монгол улсын Олноо Өргөгдсөн Богд хааны түүх. УБ., 2001

²⁴ мөн тэнд, т-60

бичлэгт Энэтхэг, Түвдийн шашны түүх бичлэгийн нөлөө үлэмж нэвтэрсэнтэй холбоотой юм.

Гэтэлгэгч Дарнадын хувилгаадын дүр дүрийн намтар хийгээд бурхны шашин соёлын эртний их гүн барилдлагаар хэлүүлж, Энэтхэг, Төвд, Монголын хаадыг төр шашны хос ёсны уламжлалын хэлхээ холбоонд дөрөөлүүлэн, Монгол улсын санваарыг хичээгч Олноо Өргөгдсөн Богд Жавзандамба хааны түүхийг хүүрнэн өгүүлсэн энэхүү зохиол бол Монголын түүх, шашин, соёл, ялангуяа монгол үндэстний наран хэдэнтээ мандаж, нэгэнтээ шингэж, дахинтаа мандсан сүүлийн 300-гаад жилийн түүхнээ "бурхан" явсан Жавзандамба хутагт, хувилгаадын намтар тэргүүтнийг шинжлэн судлахад чухаг эх сурвалж бичиг юм. 188 хуудас бүхий гар бичмэл энэхүү судрыг анх 1915 онд Богд хаант Монгол Улсын сангаас дэмжин монгол хэлээр орчуулж, 2 ботиор хорголжин бараар монгол бичгээр хэвлэсэн аж. Гэвч эдүээ энэ зохиол нь ховордож, олдохуйяа бэрх болсоны зэрэгцээгээр орчин цагийн монгол хэлнээ байхгүй учир "Монголын түүхт хүмүүс" сэдэвт ажлын хүрээнд доктор Д.Дашбадрах кирилл бичигт буулган хэвлүүлсэн юм.

Энэ үеийн түвд хэл дээр бичигдсэн түүхийн зохиолын нэг бол Сэцэн хан аймгийн Жонон вангийн хошууны харъяат, Зүүн Хүрээний дацан Балданбарайвун Дашцэпэллингийн гавж лам Бадамцэрэнгийн монголоор зохиосон "Богд Жибзундамба хаан ширээнд заларсны нууц түүх- Ялгуулсан хөвгүүний баясгалангийн хуримын далай хэмээгдэх оршвой" бүгд 55 хуудас, тахилын болон төгсгөлийн үгтэй зохиолыг дурдаж болох юм. Энэ зохиолын тухай Д.Дашбадрах "Наймдугаар Жибзундамба намтар" Ялгуулсан хөвгүүний баясгалангийн хуримын далай" хэмээх зохиолын тухай өгүүллийг нийтлүүлсэн байна. Түүхч З.Лонжид уг зохиол Улсын төв номын санд 1980 онд байсан боловч эдүгээ олдохгүй байна хэмээн дурджээ¹.

Энэ үеийн түүх бичлэгийн нэг онцлог бол гадаадын зохиогчдын ном бүтээлийг монгол хэл дээр орчуулахын хамт монгол түүхчдийн түвд хэл дээр бичсэн зохиолуудыг тухайн үеийн төр, шашны захиалгаар орчуулан хэвлэж байжээ. Энэ тухайд "...Богд хааны зарлигийн боолд багтсан ном хийгээд билгээр маш уужим сойвон Пунцагцэрэн бээр урьдаас дурдсан бөгөөд, хойно өөрийн хийдийн орон дээд бурханы шашны эзэн дээдсүүдийн зарлигаар ... Агваанпринлэйжамцын 1915 онд

¹ З.Лонжид. Богд хаантан ба Монголын түүх бичлэг/1915-2004/. XX зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал. УБ.,2005